

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАЛЫН УРИЛГА

Огноо : 2020.04.02

Сонгон шалгаруулалтын нэр: **Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших “9-р хүдрийн бүс” нэртэй MV-012884 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ордод бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах**

Монголросцветмет ТӨҮГ нь эрх бүхий оролцогчдоос бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

Сонгон шалгаруулалтын баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50000** төгрөгөөр худалдан авч болно. Санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **сүүлийн 2 жил буюу 2018 он, 2019 он.** Борлуулалтын орлогын хэмжээ нь **500 сая төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **300 сая төгрөгөөс багагүй байх ба харилцагч банкнаас тодорхойлолт авах тохиолдолд уг саналд ялсан тохиолдолд зээл олгох боломжтой байна гэсэн утга бүхий банкны тодорхойлолтыг шаардлага хангасан материал гэж үзнэ.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **сүүлийн 2 жил буюу 2018 он, 2019 он**

Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил: **сүүлийн 2 жил буюу 2018 он, 2019 он**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **тийм, ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Уул уурхайн ашиглалт, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх бүхий тэмдэглэлтэй байх**

Саналыг **2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минут**–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан саналыг **2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 11 цаг 00 минут** -т нээнэ.

Гадаадын этгээд санал ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Эрхгүй
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд саналын баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002
Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө. 22-р хороо,
“Монголросцветмет” ТӨҮГ-ийн байр, 504 тоот өрөө,
И-мейл: mailbox@monros.mn.
Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-450060-152,